


ШАТАХУУН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Тус яаманд “Өлзийт зам холбоо” ТББ-ийн 2026 оны 07/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн гомдлын дагуу Зам, тээврийн салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2026 оны 04/08 дугаартай удирдамжийн хүрээнд Улаанбаатар-Мандалговь чиглэлийн улсын чанартай авто зам дагуу байршилтай “Түргэний гүүр”, “Мандалговь” төлбөр авах цэгээр дайран өнгөрч буй шатахуун тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан нийтлэг эрх, үүргийн хүрээнд Авто замын тухай, Автотээврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хийж гүйцэтгэсэн.



“Түргэний гүүр” төлбөр авах цэгийн хяналт шалгалт

Улсын чанартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн А0201 дугаартай авто замд байршилтай “Түргэний гүүр” төлбөр авах цэгийн төлбөрийг цахим хэлбэрээр авч байгаа бөгөөд 2019 онд ашиглалтад орсон ХК3190-М1 загварын автомашины динамик пүүг ашиглаж байна. Стандартчилал, хэмжил зүйн газраас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-д ашиглаж буй дээрх жинг баталгаажуулан 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 0003403 дугаартай гэрчилгээг нэг жилийн хугацаатай олгосон боловч хяналт шалгалт хийх явцад ажиллагаагүй байсан тул тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техникийн баримт бичгийн бүрдэл, ачилтын баримт, бодит жингийн судалгааг авч ажилласан.



“Мандалговь” төлбөр авах цэгийн хяналт шалгалт

“Мандалговь” төлбөр авах цэгийн 2021 онд ашиглалтад орсон ХК3190-А9 загварын авто машины динамик пүүг ашиглаж байна. Стандартчилал, хэмжил зүйн газраас “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-д ашиглаж буй дээрх жинг баталгаажуулан 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 002068 дугаартай гэрчилгээг 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл олгосон байна. Тус ТАЦ-т урдаас хойш явах чиглэлд нэг авто пүү ажиллуулж байна.

Шалгалтаар шатахуун ачсан 9 автотээврийн хэрэгсэл нь “Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2025 стандартад заасан тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх бодит жингийн дээд хэмжээнээс 4.5-9 тонноор илүү даац хэтрүүлэн олон улс, улсын чанартай авто замаар шатахууны тээвэрлэлтийг гүйцэтгэж байсан бөгөөд зөвхөн 1 автомашин нь стандартын дагуу тээвэрлэлт хийж байсан.

Тус хяналт шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Шалгалтад хамрагдсан шатахуун ачсан 8 автотээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх бодит жингийн дээд хэмжээнээс 4.5-9.0 тонноор илүү даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж байсан;
2. Шатахуун тээвэрлэх автоцистерний торхны хийц, хэмжээг өөрчлөн хөндлөн болон босоо байрлалаар тастаж шавж гагнасан, шүүрсэн байгаа нь “Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлага” MNS4978:2025 стандартын шаардлагыг зөрчсөн;



Автоцистерний торхны хийц, хэмжээг өөрчлөн хөндлөн болон босоо байрлалаар тастаж шавж гагнасан, шүүрсэн байгаа байдал

3. Шатахуун тээвэрлэх автоцистерний торхны хийц, хэмжээг өөрчилсөн автотээврийн хэрэгсэлд галын аюулгүй байдлын дүгнэлт гаргасан;
4. Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлагыг хангаагүй автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж, тэнцүүлсэн;
5. Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь аюултай ачаа тээвэрлэх сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй;
6. Аюултай ачаа тээвэрлэх автотээврийн хэрэгсэл нь байршил тогтоох төхөөрөмж (GPS), эсхүл тахографаар тоноглогдоогүй;
7. “Түргэний гүүр”, “Мандалговь” төлбөр авах цэгийн пүүний операторууд нь 2025 оны 11 дүгээр сараас хойш хяналтын журнал хөтлөөгүй;
8. Даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж байгаа автотээврийн хэрэгслүүд нь төлбөр авах цэгийг тойрон шороон замаар тээвэрлэлтийг гүйцэтгэж байсан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, төлбөр авах цэгийн авто пүүг ажиллагаанд оруулах, ашиглалтын байдалд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран үзлэг шалгалтыг хийж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт, хийц, хэмжээг өөрчилсөн

автотээврийн хэрэгслийг аюултай ачааны тээвэрлэлтэд ашиглуулахгүй, ачилт хийлгэхгүй байх, нийслэл болон орон нутагт ашиглагдаж байгаа шатахуун тээвэрлэх автоцистернүүдийн үзлэг шалгалтыг хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах, холбогдох стандартын дагуу ачилт хийж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах талаар холбогдох төрийн байгууллага руу тус яамны СХШҮДАГ-ын нийт 6 албан бичиг (Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Цагдаагийн ерөнхий газар, АТГ, Нийслэлийн Онцгой байдлын газар, "АТҮТ" ТӨҮГ, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ)-ийг хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 7 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу аюултай ачааны тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийг GPS-ийн цахим хяналтын системд бүрэн холбон тээвэрлэлтийн чиглэлд хяналт тавих, шатахуун тээвэрлэх том оврын тээврийн хэрэгслийг холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу замын хөдөлгөөнд оролцуулах, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР